

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/12






Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга
сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн Даргаар Цэвэгжавын Одмааг сонгосугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн Дарга (Ц.Одмаа)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ТУЗ-ийн гишүүд:

	/О.БОЛДБААТАР/		/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/
	/В.БАЯРСАЙХАН/		/Ц.ОДМАА/
	/Н.ЦЭВЭГМИД/		/С.ЭНХ-АМГАЛАН/
	/С.БОРГИЛ/		/Ж.ЖАРГАЛСҮРЭН/
	/Б.ӨЛЗИЙБААТАР/		

Stamp: ТУЗ-ийн гишүүд: ЛЭНДМН ББСБ ХК, 5039754, 1118267206, Улаанбаатар хот

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/13

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргыг улируулан томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 13 дугаа зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, ТУЗ-ийн Даргын 2021 оны 4 сарын 23-ны өдрийн санал, ТУЗ-ийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Жаргалсайханы Мөнхцэцэгийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар улируулан томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудсан дахь мэдээлэл холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/14

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:
 - а. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;
Гишүүд: О.Болдбаатар;
С.Энх-Амгалан;
В.Баярсайхан;
Н.Цэвэгмид
Б.Өлзийбаяр.
 - б. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Ж.Жаргалсүрэн;
Гишүүд: Ц.Одмаа;
С.Боргил.
 - в. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: С.Энх-амгалан;
Гишүүд: С.Боргил;
Б.Өлзийбаяр.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



/Ц.ОДМАА/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/15

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ээлжит хурлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2021 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Ц.Одмаа)-д үүрэг болгосугай.



ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 4 сарын 23-ны өдрийн 21/15 тоот тогтоолын Хавсралт 1



ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2021 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУВААРЬ

	ТУЗ-ийн ээлжит хурал	Огноо	Гариг
1	II улирлын ээлжит хурал	2021 оны 07 сарын 29	Пүрэв
2	III улирлын ээлжит хурал	2021 оны 10 сарын 21	Пүрэв
3	IV улирлын ээлжит хурал	2021 оны 12 сарын 23	Пүрэв
4	2021 оны жилийн эцсийн хурал	2022 оны 02 сарын 04	Баасан

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/16

Улаанбаатар хот

Эрх бүхий этгээд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дахь хэсэг, Иргэний хуулийн 64 дүээр зүйлийн 64.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд компанийн нэр дээр данс нээлгэх, дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдээр компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-ыг томилсугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 23-ны өдөр

№ 21/17

Улаанбаатар хот

Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.4 болон 49.5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4 дахь хэсэг, ТУЗ-ийн 2021 оны 4 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй хэмжээний хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.



ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 4 сарын 23-ны өдрийн 21/17 тоот тогтоолын Хавсралт 1



КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ		
1.	Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 10 /арав/ хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
2.	Дараалсан 30 хоногийн хугацаанд эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 25 хувиас хэтрэхгүй. Энэ журам нь доорх 4 дэх хэсэгт заасан Багц худалдан авалтад хамаарахгүй.
3.	Хувьцааг эргүүлэн худалдаж авах дээд үнэ	Өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй.
4.	Багц арилжааны худалдан авах ханшийн дээд хязгаар	Нийлбэр дүнгээрээ 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцаа эргүүлэн худалдаж авах багц арилжааны хэлцлийн нэгж хувьцааны ханш нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 105 (нэг зуун тав) хувиас хэтрэхгүй
5.	Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа	2021 оны 04 сарын 23-ны өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал.
6.	Мэдээлэл түгээх	Долоо хоног тутмын баасан гарагт тухайн долоо хоногт халаасалсан хувьцааны тоо, дундаж ханшийн талаарх мэдээллийг Компанийн www.lend.mn болон Хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.